



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Захиргааны эрх зүйн маргаан)¹

ЗАСГИЙН ГАЗРААС АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙГ УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНД АВСАН ТОХИОЛДОЛД НӨХӨХ ОЛГОВРЫГ ОЛГОХ ХЭЛБЭР НЬ ЗАХИРГААНЫ СОНГОХ БОЛОМЖИД ХАМААРНА

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 001/ХТ2026/0043

Шүүхийн шийдвэрийн огноо: 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

Шийдвэрийн төрөл: Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Нэхэмжлэгч хуулийн этгээдэд Ашигт малтмал газрын тосны газраас *** аймгийн *** сумын нутаг дэвсгэрт **ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий 23301.63 гектар талбайг олгосон байдаг**. Харин Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 183 дугаар шийдвэрээр тухайн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайгаас **950.77 гектар талбайг “газрын тосны тос дамжуулах хоолойн трасс”-ийн давхцалтай, хайгуулын үйл ажиллагаа явуулах боломжгүй гэх үндэслэлээр улсын тусгай хэрэгцээнд авчээ.**

Нэхэмжлэгч хуулийн этгээдээс тусгай хэрэгцээнд авсан талбайн нөхөн олговрыг олгохгүй байгаа эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгож, Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13-т заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хэлэлцэн тохирсны үндсэн дээр тусгай зөвшөөрөл бүхий **талбайтай дүйцүүлэн улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын явцад тогтоогдсон эрдсийн хуримтлал бүхий талбайгаас нөхөн олгохыг даалгуулахаар маргасан байна.**

Харин хариуцагч Засгийн газраас “... Ашигт малтмалын тухай хуулийн² 9 дүгээр зүйлийн 9.1.13, Газрын тухай хууль болон Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ заагийг тогтоох, ашиглах журам”-д заасан холбогдох зохицуулалтын хүрээнд **талбай дүйцүүлэн олгох газрын асуудал Засгийн газрын хэмжээнд шийдвэрлэгдээгүй байгаа тул улсын тусгай хэрэгцээнд авсан газар өөр талбай дүйцүүлэн олгох боломжгүй...**” гэж тайлбарлан маргажээ.

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: https://shuukh.mn/single_case/3494?daterange=2025-10-28%20-%202026-06-08&id=3&court_cat=3&bb=1.

² Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2006 он, №30.



ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. **Давж заалдах шатны шүүхээс:** Давж заалдах шатны шүүх Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13³, 14 дүгээр зүйлийн 14.4⁴-т заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч хуулийн этгээдийн Монгол Улсын Засгийн газарт холбогдуулан гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, нэхэмжлэгч хуулийн этгээдийн *** дугаар тусгай зөвшөөрөл бүхий ашигт малтмалын хайгуулын талбайг хэсэгчлэн төрийн мэдэлд шилжүүлэн авсны нөхөх олговрыг олгохгүй байгаа **Монгол Улсын Засгийн газрын эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоож, нөхөх олговор авах хүсэлтийг хуульд заасан журмын дагуу даалгаж шийдвэрлэжээ.**
2. **Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн давж заалдах гомдлын үндэслэл:** Хариуцагч Засгийн газрын зүгээс “Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.21-д “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэж энэ хуулийн дагуу ашигт малтмал эрэх, хайх, ашиглах эрх авсан, эсхүл түүнийг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу шилжүүлэн авсан хуулийн этгээд гэж тодорхойлсон. Нэхэмжлэгч хуулийн этгээдийн хувьд өөрийн тусгай зөвшөөрөл бүхий үлдсэн 1619.76 гектар талбайг “Д” ХХК-д шилжүүлсэн учраас тусгай зөвшөөрөл эзэмших эрхээ алдсан бөгөөд нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн нь тодорхойгүй байх тул нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан...” гэх үндэслэлээр давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгуулах агуулга бүхий гомдол гаргажээ.
3. **Хяналтын шатны шүүхээс:** Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9 дүгээр зүйлийн 9.1.13, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт заасны дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг улсын тусгай хэрэгцээнд авсны улмаас тусгай зөвшөөрөл эзэмшигч ашигт малтмал эрэх, хайх, ашиглах боломжгүй болсон бол тусгай зөвшөөрөл эзэмшигч хуульд заасан үндэслэл журмын дагуу нөхөх олговор шаардах эрхтэй, нөгөө талаас нөхөх олговор зайлшгүй олгох үүргийг Засгийн газарт хүлээлгэсэн. Харин, **нөхөх олговрыг олгохдоо дүйцүүлэн өөр талбай олгох, эсхүл мөнгөн дүнгээр олгож болохоор сонгох боломжийг Засгийн газарт олгожээ. (13)⁵**

³ Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13 дахь хэсэг “*ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгосон талбайг үндэсний аюулгүй байдлыг хангах, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх томоохон хэмжээний төслийг хэрэгжүүлэх, тусгай хэрэгцээнд авах зорилгоор төрийн мэдэлд шилжүүлэн авч нөхөх олговрын асуудлыг шийдвэрлэхдээ тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хэлэлцэн тохирсоны үндсэн дээр улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын явцад тогтоогдсон эрдсийн хуримтлал бүхий талбай болон энэ хуулийн, 26.9-д заасан талбайгаас тусгай зөвшөөрөл олгож болно*”.

⁴ Ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг “*Хүчин төгөлдөр хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн тусгай хэрэгцээнд авснаар тусгай зөвшөөрөл эзэмшигч ашигт малтмал эрэх, хайх, ашиглах боломжгүй болсон бол тухайн шийдвэр гаргасан байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговрыг нэг жилийн дотор төлнө*”.

⁵ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.



4. Энэ хэргийн хувьд нэхэмжлэгч нь дүйцүүлэн өөр талбай олгохыг шаардсан бөгөөд **Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13-т заасан дүйцүүлэн өөр талбай олгох эсэх нь дээр дурдсанаар Засгийн газрын сонгох боломжид хамаарах төдийгүй дүйцүүлэн өөр талбай олгохыг шаардах урьдчилсан нөхцөл бүрдээгүй байна.** (14)
5. Тодруулбал, нэхэмжлэгчид хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс хойш даруй 5 сарын дараа буюу 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр талбайг тусгай хэрэгцээнд авсан байх бөгөөд нэхэмжлэгчийн зүгээс тус хугацаанд эгүүлэн авсан талбайд **ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа явуулсан талаарх нотлох баримтыг гаргаж өгөөгүй, хайгуулын талбайд үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдохгүй байна.** (15)
6. Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13-т “...улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын явцад тогтоогдсон эрдсийн хуримтлал бүхий талбай болон энэ хуулийн, 26.9-д заасан талбайгаас тусгай зөвшөөрөл олгож болно” гэж эрдсийн хуримтлал бүхий талбайгаас дүйцүүлэн өөр талбай олгож болохоор зохицуулсан байх бөгөөд хайгуул хийж эхлээгүй талбайг тусгай хэрэгцээнд авсны нөхөх олговорт төсвийн хөрөнгөөр **геологийн судалгаа хийсэн, эрдсийн хуримтлал тогтоогдсон талбай олгохыг хариуцагчаас шаардаж байгаа үндэслэл тодорхойгүй, энэ нэхэмжлэлийг шүүх хангах боломжгүй.** (16)
7. Дээрх үндэслэлүүдээр **давж заалдах шатны шүүхийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.**